



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/104

Жаргалант

**Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Хэнтий аймгийн засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/435 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зооноз, архаг халдварт малын бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад сумын хэмжээний нийт охин төлийг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын удирдамж, стандарт ажиллагааны зааврын хүрээнд уг ажлыг шуурхай зохион байгуулах, дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын явц, технологи, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (О.Банхар)-д, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын мэдээ тайлан, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Э.Батдаваа)-д нарт үүрэг болгосугай.

3. Графикт хугацаанд нь мал үлдээлгүй дархлаажуулахыг Тахир нуур ХХК мал эмнэлгийн малын эмч С.Сугаррагчаа, Эм Тун ХХК-ний захирал, малын эмч Э.Батцэцэг, Бодь-Тара ХХК-ний малын эмч Г.Гомбосүрэн нарт үүрэг болгосугай.

4. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлдүүлэн, зарлан мэдээлэл хүргэж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (О.Банхар)-д үүрэг болгосугай.

6. Төлөвлөгөөт ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501240



Сумын Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн
А/104 дугаар захирамжийн хавсралт

БРУЦЕЛЛЭЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

2025.07.30

№	Сумын нэр	МЭҮН	Дархлаажуулалтад хамруулах мал /толгой/					Шаардагдах вакцины хэмжээ						Шингэлэгч /литр/		
			Тугал	Хурга	Ишиг	Бод	Бог	Бүгд	br. Abortus-19 омог	Br. Mellitensis Rev-1						
1	Норовлин	Эм Тун	6000	12313	7187	6000	19500	25500	100 тун /ширхэг/	Нийт тун	500 тун	400 тун	300 тун	Нийт тун	19500	31.50
			1900	3250	2250	1900	5500	7400		19	1900	11		5500	9.30	
			2500	9000	4500	2500	13500	16000		25	2500	27		13500	18.50	
		Бүгд	10400	24563	13937	10400	38500	48900	104	10400	77			38500	59.30	